

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН ХАРЬЯА  
ХОВД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газрын 2021 оны санхүүгийн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: ХОА-2022/81/НА/-СТА-ТШЗ

Цахим хуудас:  
[www.audit.mn](http://www.audit.mn)

Ховд хот  
2022 он

Тэргүүлэх аудитор: Х.Болдбаатар

Утас: 70433061

Цахим хаяг: Boldbaatar.Kh @audit.gov.mn

Аудитын менежер: А.Цэцэгсүрэн

Утас: 70432545

Цахим хаяг: tsetsegsuren.a@audit.gov.mn

Аудитор: Б.Должинжав

Утас: 89898557

цахим хаяг: Doljinjavb@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## Агуулга

1.Аудит санал дүгнэлт .....	Error! Bookmark not defined.
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл.....	3
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан .....	3
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан .....	4
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан .....	5
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	6
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан .....	8
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан .....	10
3. Аудитын тайлан .....	11
3.1 Ерөнхий зүйл .....	11
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт.....	11
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал .....	12
3.4 Материаллаг байдал .....	12
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга .....	12
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв .....	13
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг.....	14
3.8 Аудитын гол асуудал .....	14
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	14
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт.....	14
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	14
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	14
4. Аудитын илрүүлэлт.....	14
4.1 Залруулсан алдаа .....	15
4.2 Зөвлөмж .....	15
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл .....	16

### Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
ТШЗ	Төсвийн шууд захирагч
СТА	Санхүүгийн тайлангийн аудит
НА	Нотлох ажил



**ХОВД АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

84000 Цамбагарав баг, Жаргалант сум, Ховд  
Утас: 976-70433061, Факс: 976-70433061  
E-mail: khovd@audit.gov.mn

2022.02.25 № 2/66  
танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

ГЭР БҮЛ, ХҮҮХЭД  
ЗАЛУУЧУУДЫН ХӨГЖЛИЙН ГАЗРЫН  
ДАРГА Б.БАЯРТУЯА ТАНАА

**ЗӨРЧИЛГҮЙ ДҮГНЭЛТ**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР:  Х.БОЛДБААТАР



## 2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

## 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Төгрөгөөр

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	54,988,203.50	66,433,040.32
33	АВЛАГА	404,596.50	310,029.32
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	83,246.00	226,919.32
33300	Татаас, санхүүжилтийн авлага	320,700.00	-
335	Бусад авлага	650.50	83,110.00
3351	Байгууллагаас авах авлага	650.50	83,110.00
35	БАРАА МАТЕРИАЛ	54,583,607.00	66,123,011.00
354	Хангамжийн материал	54,583,607.00	66,123,011.00
35420	Аж ахуйн материал	51,687,857.00	64,355,111.00
35440	Түлш, шатах тослох материал	2,895,750.00	1,767,900.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	1,401,695,667.10	1,420,475,022.24
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1,401,695,667.10	1,420,475,022.24
392	Биет хөрөнгө	1,319,524,062.82	1,338,470,584.68
39201	Барилга, байгууламж, орон сууц	1,147,150,280.00	1,147,150,280.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	(38,238,342.72)	(57,357,514.08)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	23,500,000.00	23,500,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(4,308,333.30)	(6,658,333.26)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	130,509,187.00	181,180,167.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	(98,830,150.72)	(110,909,565.23)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	169,134,309.00	180,954,856.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	(144,302,936.64)	(150,132,689.31)
39214	Бусад үндсэн хөрөнгө	178,367,170.00	178,367,170.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	(58,223,119.80)	(62,389,786.44)
39217	Ном	14,766,000.00	14,766,000.00
393	Биет бус хөрөнгө	82,171,604.28	82,004,437.56
39301	Програм хангамж	7,093,000.00	7,093,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(5,825,995.72)	(5,993,162.44)
39303	Бусад биет бус хөрөнгө	80,904,600.00	80,904,600.00
3	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b>1,456,683,870.60</b>	<b>1,486,908,062.56</b>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	3,564,001.84	18,801.66
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	3,564,001.84	18,801.66
413	Өглөг	3,564,001.84	18,801.66
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	1,156,963.84	18,801.66
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	1,546,038.00	-
4136	Бусад өглөг	861,000.00	-
41361	Байгууллагад төлөх өглөг	861,000.00	-
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	1,453,119,868.76	1,486,889,260.90
512	Хуримтлагдсан үр дүн	(646,833,389.33)	(613,063,997.19)
51210	Өмнөх үеийн үр дүн	(646,833,389.33)	(646,833,389.33)

51220	Тайлант үеийн үр дүн	-	33,769,392.14
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	798,270,586.09	798,270,586.09
6	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	1,456,683,870.60	1,486,908,062.56

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Төгрөгөөр

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН</b>	731,760,851.00	819,834,100.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	36,848,151.00	45,414,200.00
120	Нийтлэг татварын бус орлого	36,848,151.00	45,414,200.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	36,848,151.00	45,414,200.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	5,942,191.00	3,093,000.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	30,905,960.00	42,321,200.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	694,912,700.00	774,419,900.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	512,484,100.00	545,210,500.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	512,484,100.00	545,210,500.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	38,819,100.00	85,599,900.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	23,000,000.00	17,466,900.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	14,654,900.00	68,133,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	1,164,200.00	
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	143,609,500.00	143,609,500.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	143,609,500.00	143,609,500.00
2	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	713,661,931.94	786,064,707.86
21	УРСГАЛ ЗАРДАЛ	713,661,931.94	786,064,707.86
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	621,770,353.66	707,491,224.60
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	252,973,400.00	300,430,445.00
210101	Үндсэн цалин	218,461,098.00	263,553,975.00
210102	Нэмэгдэл	34,512,302.00	36,876,470.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	32,352,452.42	39,313,573.24
210201	Тэтгэврийн даатгал	22,135,990.53	27,352,012.06
210202	Тэтгэмжийн даатгал	2,564,081.92	2,993,894.77
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,041,185.54	2,395,115.81
210204	Ажилгүйдлийн даатгал	508,230.59	584,761.06
210205	Эрүүл мэндийн даатгал	5,102,963.84	5,987,789.54
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	127,155,471.00	141,182,391.00
210301	Гэрэл, цахилгаан	3,483,538.00	3,749,262.00
210302	Түлш, халаалт	120,361,133.00	134,000,748.00
210303	Цэвэр, бохир ус	3,310,800.00	3,432,381.00
2104	Хангамж, бараа материалын зардал	109,194,139.10	126,264,293.50
210401	Бичиг хэрэг	4,640,520.00	635,500.00

210402	Тээвэр, шатахуун	3,548,039.50	5,047,800.50
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,586,251.60	1,279,700.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	445,000.00	164,000.00
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал	98,974,328.00	119,137,293.00
2105	Нормативт зардал	168,600.00	-
210502	Хоол, хүнс	168,600.00	-
2107	Томилолт, зочны зардал	878,000.00	-
210702	Дотоод албан томилолт	878,000.00	-
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	40,191,323.54	34,332,681.76
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	39,616,816.54	33,371,001.76
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	320,000.00	430,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	-	100,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	52,000.00	53,680.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	16,500.00	36,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	86,007.00	342,000.00
210807	Газрын төлбөр	100,000.00	-
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	58,856,967.60	65,967,840.10
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	15,157,628.00	3,654,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	405,000.00	18,765,417.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	43,294,339.60	43,548,423.10
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	91,891,578.28	78,573,483.26
2132	Бусад урсгал шилжүүлэг	16,620,500.00	68,192,600.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	15,920,500.00	68,192,600.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	700,000.00	-
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	75,271,078.28	10,380,883.26
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	75,271,078.28	10,380,883.26
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН	18,098,919.06	33,769,392.14
5	<b>НИЙТ ҮР ДҮН</b>	18,098,919.06	33,769,392.14

### 2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Төгрөгөөр

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2020 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл	1,301,682,672.00	798,270,586.09	(663,711,908.39)	1,436,241,349.70
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	(1,220,400.00)	(1,220,400.00)
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,301,682,672.00	798,270,586.09	(664,932,308.39)	1,435,020,949.70
C07	Тайлант үеийн үр дүн	-	-	18,098,919.06	18,098,919.06

C08	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,301,682,672.00	798,270,586.09	(646,833,389.33)	1,453,119,868.76
D01	2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	1,301,682,672.00	798,270,586.09	(646,833,389.33)	1,453,119,868.76
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,301,682,672.00	798,270,586.09	(646,833,389.33)	1,453,119,868.76
D08	Тайлант үеийн үр дүн	-	-	33,769,392.14	33,769,392.14
D09	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,301,682,672.00	798,270,586.09	(613,063,997.19)	1,486,889,260.90

## 2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Төгрөгөөр

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	700,854,891.00	777,833,600.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	5,942,191.00	3,093,000.00
120	Нийтлэг татварын бус орлого	5,942,191.00	3,093,000.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	5,942,191.00	3,093,000.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	5,942,191.00	
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	694,912,700.00	774,740,600.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	512,484,100.00	545,210,500.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	512,484,100.00	545,210,500.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	38,819,100.00	85,920,600.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	23,000,000.00	17,787,600.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	14,654,900.00	68,133,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	1,164,200.00	
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	143,609,500.00	143,609,500.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	143,609,500.00	143,609,500.00
2	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	684,215,090.88	777,833,600.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	684,215,090.88	777,833,600.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	591,802,812.60	699,260,116.74
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	193,948,300.00	222,072,254.00
210101	Үндсэн цалин	129,657,020.55	128,564,868.00
210102	Нэмэгдэл	64,291,279.45	50,505,622.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	-	5,157,029.00
210104	Урамшуулал	-	29,530,935.00
210105	Гэрээт ажлын хөлс	-	8,313,800.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	26,182,900.00	32,362,100.00

210201	Тэтгэврийн даатгал	18,425,100.00	22,773,300.00
210202	Тэтгэмжийн даатгал	1,939,500.00	2,397,300.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,551,600.00	1,917,700.00
210204	Ажилгүйдлийн даатгал	387,700.00	479,400.00
210205	Эрүүл мэндийн даатгал	3,879,000.00	4,794,400.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	125,845,633.00	142,728,429.00
210301	Гэрэл, цахилгаан	2,834,500.00	4,634,500.00
210302	Түлш, халаалт	120,361,133.00	134,000,748.00
210303	Цэвэр, бохир ус	2,650,000.00	4,093,181.00
2104	Хангамж, бараа материалын зардал	6,374,100.00	6,132,850.00
210401	Бичиг хэрэг	2,471,600.00	2,400,000.00
210402	Тээвэр, шатахуун	1,798,500.00	1,763,550.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,000,000.00	849,300.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,104,000.00	1,120,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,890,200.00	-
210604	Урсгал засвар	1,890,200.00	-
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	212,032,279.60	208,803,708.74
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	210,945,780.00	207,684,028.74
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	320,000.00	430,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	90,000.00	100,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	60,000.00	53,680.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	16,500.00	36,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	499,999.60	500,000.00
210807	Газрын төлбөр	100,000.00	-
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	25,529,400.00	87,160,775.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	16,250,000.00	6,104,700.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	9,279,400.00	81,056,075.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	92,412,278.28	78,573,483.26
2132	Бусад урсгал шилжүүлэг	16,820,500.00	68,192,600.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	15,920,500.00	68,192,600.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	900,000.00	-
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	75,591,778.28	10,380,883.26
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	75,591,778.28	10,380,883.26
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	16,639,800.12	-
	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	16,639,800.12	-
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	16,639,800.12	-
2200	Дотоод эх үүсвэрээр	16,639,800.12	-
223001	Бусад хөрөнгө	16,639,800.12	

6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	(16,639,800.12)	-
	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	-	-
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	-	-
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Төгрөгөөр

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү
2	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	695,670,000.00	681,532,116.74	(14,137,883.26)
21	УРСГАЛ ЗАРДАЛ	695,670,000.00	681,532,116.74	(14,137,883.26)
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	627,477,400.00	613,339,516.74	(14,137,883.26)
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	239,718,600.00	222,072,254.00	(17,646,346.00)
210101	Үндсэн цалин	139,087,500.00	128,564,868.00	(10,522,632.00)
210102	Нэмэгдэл	54,860,800.00	50,505,622.00	(4,355,178.00)
210103	Унаа хоолны хөнгөлөлт	-	5,157,029.00	5,157,029.00
210104	Урамшуулал	37,456,500.00	29,530,935.00	(7,925,565.00)
210105	Гэрээт ажлын хөлс	8,313,800.00	8,313,800.00	-
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	32,362,100.00	32,362,100.00	-
210201	Тэтгэврийн даатгал	22,773,300.00	22,773,300.00	-
210202	Тэтгэмжийн даатгал	2,397,300.00	2,397,300.00	-
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,917,700.00	1,917,700.00	-
210204	Ажилгүйдлийн даатгал	479,400.00	479,400.00	-
210205	Эрүүл мэндийн даатгал	4,794,400.00	4,794,400.00	-
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	143,533,800.00	136,581,529.00	(6,952,271.00)
210301	Гэрэл, цахилгаан	2,834,500.00	2,834,500.00	-

210302	Түлш, халаалт	138,049,300.00	131,453,848.00	(6,595,452.00)
210303	Цэвэр, бохир ус	2,650,000.00	2,293,181.00	(356,819.00)
2104	Хангамж, бараа материалын зардал	6,420,000.00	6,132,850.00	(287,150.00)
210401	Бичиг хэрэг	2,500,000.00	2,400,000.00	(100,000.00)
210402	Тээвэр, шатахуун	1,800,000.00	1,763,550.00	(36,450.00)
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,000,000.00	849,300.00	(150,700.00)
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,120,000.00	1,120,000.00	-
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	75,700.00	-	(75,700.00)
210604	Урсгал засвар	75,700.00	-	(75,700.00)
2107	Томилолт, зочны зардал	719,800.00	-	(719,800.00)
210702	Дотоод албан томилолт	719,800.00	-	(719,800.00)
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	194,975,900.00	208,503,708.74	13,527,808.74
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	193,140,900.00	207,384,028.74	14,243,128.74
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	430,000.00	430,000.00	-
210803	Даатгалын үйлчилгээ	198,000.00	100,000.00	(98,000.00)
210804	Тээврийн хэрэгслийн татвар	66,000.00	53,680.00	(12,320.00)
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	36,000.00	36,000.00	-
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	500,000.00	500,000.00	-
210807	Газрын төлбөр	605,000.00	-	(605,000.00)
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	9,671,500.00	7,687,075.00	(1,984,425.00)
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	9,671,500.00	7,687,075.00	(1,984,425.00)
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	68,192,600.00	68,192,600.00	-
2132	Бусад урсгал шилжүүлэг	68,192,600.00	68,192,600.00	-
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	68,192,600.00	68,192,600.00	-
	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	695,670,000.00	681,532,116.74	(14,137,883.26)
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	545,210,500.00	541,942,968.74	(3,267,531.26)

131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	545,210,500.00	541,942,968.74	(3,267,531.26)
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	143,609,500.00	136,496,148.00	(7,113,352.00)
132001	Орон нутгийн төсвөөс	143,609,500.00	136,496,148.00	(7,113,352.00)
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	6,850,000.00	3,093,000.00	(3,757,000.00)
1E+06	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	6,850,000.00	3,093,000.00	(3,757,000.00)
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл			-
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл			-
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1	1	
610001	Төсвийн байгууллага			
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	36	36	
620001	Удирдах ажилтан	1	1	
620002	Гүйцэтгэх ажилтан	21	21	
620003	Үйлчлэх ажилтан	11	11	
620004	Гэрээт ажилтан	3	3	

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Төгрөгөөр

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Гүйцэтгэл
I	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	38,819,100.00	85,920,600.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	38,819,100.00	85,920,600.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	38,498,400.00	85,920,600.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	-	6,146,900.00
210301	Гэрэл, цахилгаан		1,800,000.00
210302	Түлш, халаалт		2,546,900.00
210303	Цэвэр, бохир ус		1,800,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	18,120,000.00	-
210604	Урсгал засвар	18,120,000.00	
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	4,128,400.00	300,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	4,128,400.00	300,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	16,250,000.00	79,473,700.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	16,250,000.00	6,104,700.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх		73,369,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	320,700.00	-
2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг	320,700.00	-
213403	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, төвлөрүүлэх шилжүүлэг	320,700.00	
II	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	38,819,100.00	85,920,600.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	38,819,100.00	85,920,600.00

131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	23,000,000.00	17,787,600.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	14,654,900.00	68,133,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	1,164,200.00	
IV	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)		
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-

### 3. Аудитын тайлан

#### 3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх дуусгавар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд төсвийн гүйцэтгэл, үр ашиг, арвилан хэмнэлт, Засгийн газрын 43 дугаар тогтоолын хэрэгжилттэй холбоотой асуудлаар зөвлөмж өгсөн болно.

Аудитыг аудитор Б.Должинжав 2022 оны 02 дугаар сарын 18-аас 02 дугаар сарын 21-ны хооронд гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер А.Цэцэгсүрэн, газрын дарга, тэргүүлэх аудитор Х.Болдбаатар нар тус тус хэрэгжүүлсэн.

Тус байгууллага нь 2021 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Ховд аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 2 дугаар сарын 08-ны өдрийн 58 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

#### 3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газар нь “Гэр бүлийн үнэт зүйлийг бэхжүүлж тогтвортой байдлыг хангах замаар хүүхэд залуучуудын хөгжил, оролцоог дэмжиж, хүүхэд бүрийг хамгаална” гэсэн эрхэм зорилгын хүрээнд байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 4 зорилтын 28 арга хэмжээ тусгаснаас жилийн эцсийн хэрэгжилт 98.5 хувьтай буюу “бүрэн хангалттай” гэж үнэлгээтэй хэрэгжүүлжээ.

Чиг үүрэг: Хууль тогтоомж, бодлого, хөтөлбөрийг хүний эрхэд суурилсан хандлага, өсвөр үе залуучуудын үзэл бодол болон гэр бүлийн хөгжлийн хэрэгцээнд нийцүүлэхэд нөлөөлж, хуулийг сурталчлан таниулах, хэрэгжилтийг хангах ажлыг зохион байгуулах

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлт оржээ. Үүнд:

- Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолоор “төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай”
- Сангийн сайдын 2021 оны 190 дүгээр тушаалаар “Төсвийн зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар”

Тухайн онд Ховд аймгийн Засаг даргын дэргэдэх санхүүгийн хяналт дотоод аудитын албанаас тус байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд дотоод хяналт хэрэгжүүлээгүй байна.

Тус байгууллагын даргын 2020 оны 03 дугаар сарын 24 өдрийн А/15 дугаар тушаалаар баталсан нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг тухайн байгууллага санхүүгийн үйл ажиллагаандаа мөрдөн ажиллаж байна.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд аудитын зорилго оршино.

Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газар 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар бүртгэж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлан гэж үнэлсэн.

### 3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд суурь үзүүлэлтээр батлагдсан төсвийг сонгож, эрсдэлийн үнэлгээнээс хамаарч материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “бага” гэж үнэлсэн учир материаллаг байдлын түвшинг хамгийн ихээр буюу 2 хувиар тогтоосон.

Материаллаг байдлын түвшинг 2021 оны батлагдсан төсөв 695,670.0 мянган төгрөгөөс 2 хувиар буюу 13913.4 мянган төгрөгөөр тооцож, гүйцэтгэлийн материаллаг байдлыг 80 хувиар буюу 11130.7 мянган төгрөгөөр тогтоов.

### 3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газрын 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 30224.2 мянган төгрөгөөр өссөний материаллаг нөлөө нь бараа материал, үндсэн хөрөнгийн данстай холбоотой байна.

Тайлант оны эхэнд болон эцэст мөнгөн хөрөнгийн үлдэгдэлгүй байна.

Өмнөх оны үзүүлэлтэй харьцуулахад дансны авлагын үлдэгдэл 94.6 мянган төгрөгөөр буурч, бараа материалын үлдэгдэл 11539.4 мянга, үндсэн хөрөнгийн цэвэр дүн 18779.4 мянган төгрөгөөр тус тус өссөн байна.

Авлага дансны оны эхний үлдэгдэл 404.6 мянган төгрөг байсан бол оны эцэст 310.0 мянган төгрөг болж 94.6 мянган төгрөгөөр буурсан байна. Эцсийн үлдэгдэл дэх 310.0 мянган төгрөгийн авлагын 226.9 мянган төгрөг нь цалин хөлсний ХХОАТ-ын авлага, 83.1 мянган төгрөг нь шуудан холбооны авлага ба холбогдох байгууллагуудтай тооцоо нийлсэн актаар баталгаажуулсан байна.

Бараа материал дансны эхний үлдэгдэл 54583.6 мянган төгрөг байсан бол оны эцэст 66123.0 мянган төгрөг болж 11539.4 мянган төгрөгөөр өмнөх оноос өссөн үзүүлэлттэй байна. Тайлант хугацаанд төсвийн хөрөнгөөр 137193.8 мянган төгрөгийн бараа материал худалдан авч, 125654.4 мянган төгрөгийн материалыг үйл ажиллагаандаа зарцуулсан байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл оны эхэнд 1,751,424.5 мянган төгрөг байсан бол оны эцэст 1,813,916.1 мянган төгрөг болж 62,491.5 мянган төгрөгөөр нэмэгдсэнээс төсвийн хөрөнгөөр 20,170.3 мянган төгрөгийн компьютер тоног төхөөрөмж, ТЭХ худалдан авч, ГБХЗХГ-ын агентлагаас 16 сум, 12 багийн нийгмийн ажилтнууд, ГБХЗХГ-ын 3 ажилтанд зориулагдсан нийт 32 ширхэг 42321.2 мянган төгрөгийн таблетийг үнэ төлбөргүй хүлээн авч данс бүртгэлд тусгасан байна.

Тайлант оны эхэнд 3564.0 мянган төгрөгийн өр төлбөртэй байсан бол тухайн онд 3545.2 мянган төгрөгийг барагдуулж, оны эцэст 18.8 мянган төгрөгийн ажилчидтай холбоотой өр төлбөр байна.

Засгийн газрын оролцоо дансны оны эхний үлдэгдэл 1453119.9 мянган төгрөг байсан ба оны эцэст 1486889.3 мянган төгрөг болж 33769.4 мянган төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүнтэй холбоотой байна.

Өмчийн өөрчлөлтийн тайлангаар өмнөх оны үр дүнд нөлөөлсөн нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт, залруулах бичилт хийгдээгүй байна.

### **3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### **3.6.1 Төсвийн төлөвлөлт**

Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газрын 2021 оны төсвийн нийт зардлыг анх 714,524.4 мянган төгрөгөөр баталсан ба тодотголоор 18,854.4 мянган төгрөг хасаж 695,670.0 мянган төгрөгөөр батлагдсан байна.

Зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийн 545,210.5 мянган төгрөгийг тусгай зориулалтын шилжүүлгээс, 143,609.5 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс, 6,850.0 мянган төгрөгийг төсөвт байгууллагын өөрийн орлогоор санхүүжүүлэхээр баталжээ.

#### **3.6.2 Төсвийн гүйцэтгэл**

Гүйцэтгэлээр орон нутгийн төсвөөс санхүүжилт 143,609.5 мянга, тусгай зориулалтын шилжүүлгээс 545,210.5 мянган төгрөгийн санхүүжилтийг бүрэн авч, өөрийн орлого 3093.0 мянган төгрөг бүрдүүлж, урсгал үйл ажиллагаанд 681,532.1 мянган төгрөгийг зарцуулж, зарцуулагдаагүй 10,380.9 мянган төгрөгийг оны эцэст улс, орон нутгийн төсөвт буцаан төвлөрүүлжээ.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 681,532.1 мянган төгрөг буюу 97.9 хувьтай байгаа нь Цалин хөлс болон нэмэгдэл урамшлын зардлыг 17,646.3 мянга, Байр ашиглалттай холбоотой тогтмол зардлыг 6,952.2 мянга, Хангамж, бараа материалын зардлыг 287.1 мянга, Эд хогшил, урсгал засварын зардлыг 75.7 мянга, Томилт, зочны зардлыг 719.8 мянга, Бараа үйлчилгээний бусад зардлыг 1,984.4 мянга нийт 27665.7 мянган төгрөгөөр тус тус хэмнэж, Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамжийн зардлыг 13,527.8 мянган төгрөгөөр хэтрүүлж зарцуулснаас шалтгаалжээ.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын эдийн засгийн ангилал тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

#### **3.6.3 Нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу төсвийн байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансаар орон нутгийн төсвийн захирагчдаас 17466.9 мянга, дээд шатны төсвийн захирагчдаас 42193.0 мянга, НҮБ-ийн хүн амын сангийн “Хамтдаа даван тууль” төслийн санхүүжилтээр 25940.0 мянга, урьд оны татан төвлөрүүлэлт 320.7 мянга, нийт 85920.6 мянган төгрөгийн орлогын эх үүсвэр бүрдүүлж, дээрх эх үүсвэрийг зориулалтын дагуу холбогдох үйл ажиллагаанд зарцуулжээ.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын эдийн засгийн ангилал тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

### 3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

АДБОУС 706.7-д тодорхойлсон тодорхой бус байдал үүссэн, хэрэглэгчдэд хамааралтай санхүүгийн тайланд толилуулаагүй асуудал байхгүй болно.

АДБОУС 701.8-д тодорхойлсон тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх дараах ажил гүйлгээ байна.

Түр хамгаалах байрны тогтмол зардлыг төсөвт тусгуулах саналыг аймгийн СТСХ, НБХ-т удаа дараа албан бичгээр хүсэлт тавьж байсан боловч шийдвэрлээгүй байна. Тус байгууллагын байр ашиглалттай холбоотой тогтмол зардлаас тухайн онд 13722.0 мянган төгрөгийн бодит хэмнэлт үүссэн ба тус хэмнэлтийг түр хамгаалах байрны байр ашиглалттай холбоотой тогтмол зардалд зарцуулсан байна.

Засгийн газрын 43 дугаар тогтоолыг үл хэрэгсэн үндсэн үйл ажиллагаанд зайлшгүй шаардлагатайгаас бусад хэмнэх боломжтой зардлыг хэмнэж ажиллаагүй. Тухайлбал: сургалт семинар зохион байгуулах үйл ажиллагаанд 14517.4 мянга, бичиг хэрэг, аж ахуй, бусад материалын үнэд 71656.0 мянган төгрөгийн зардал гаргасан зөрчилд зөвлөмж өглөө.

### 3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасны дагуу тус байгууллагын 2021 оны Шилэн дансны хуулийн хэрэгжилтийг хяналаа.

#### 3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд шилэн дансны цахим системд цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого мэдээлээгүй, зарлагын мөнгөн гүйлгээ зөвхөн 12 дугаар сард дутуу мэдээлсэн, санхүүгийн тайлан бүтэн жилээр, тайланд хийсэн аудитын дүгнэлт, аудитын тайлан, дүгнэлт, зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тайлан мэдээлээгүй, таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээ, төсвийн гүйцэтгэлийн тайлангийн тайлант үеийн батлагдсан төсөв, гүйцэтгэл, хэтрэлт хэмнэлт, тайлбар дутуу, 4 дүгээр улирлын гүйцэтгэл мэдээлээгүй зэрэг зөрчлүүдийг шалгагдагч байгууллагаар аудитын явцад залруулж, зөрчлийг арилгууллаа.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн байна гэж дүгнэлээ.

#### 3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар тогтоосон 729.3 мянган төгрөгийн төлбөрийн актаас 429.3 мянган төгрөгийг барагдуулж, үлдэгдэл 300.0 мянган төгрөгийн төлбөрийн актыг барагдуулаагүй байна. Албан шаардлага болон зөвлөмжийн хэрэгжилтийг бүрэн хангаж ажилласан байна.

#### 3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар анхаарч үзэх чухал асуудал байхгүй гэж үзлээ.

## 4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 190,575.3 мянган төгрөгийн 5 алдаа зөрчил илэрснээс 183,409.7 мянган төгрөгийн 3 зөрчлийг аудитын явцад залруулж, 7,165.6 мянган төгрөгийн зөрчилд 2 зөвлөмж өглөө.

#### 4.1 Залруулсан алдаа

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын алдаатай дараах залруулгыг санхүүгийн тайланд тусгаж, баталгаажуулав. Үүнд:

1. Нийт 428,258.0 мянган төгрөгийн хөрөнгөөс 180,938.6 мянган төгрөгийн хөрөнгийг эд хариуцагч, агуулахын бүртгэлээр ангилан тоолж бүртгээгүй, эд хөрөнгийн тооллогын дүнд тооцоо бодож хянаагүй зөрчлийг аудитын явцад залрууллаа.

2. Тайлант хугацаанд шилэн дансны цахим системд цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого мэдээлээгүй, зарлагын мөнгөн гүйлгээ зөвхөн 12 дугаар сард дутуу мэдээлсэн, санхүүгийн тайлан бүтэн жилээр, тайланд хийсэн аудитын дүгнэлт, аудитын тайлан, дүгнэлт, зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тайлан мэдээлээгүй, таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээ, төсвийн гүйцэтгэлийн тайлангийн тайлант үеийн батлагдсан төсөв, гүйцэтгэл, хэтрэлт хэмнэлт, тайлбар дутуу, 4 дүгээр улирлын гүйцэтгэл мэдээлээгүй зэрэг зөрчлүүдийг шалгагдагч байгууллагаар аудитын явцад залруулж, зөрчлийг арилгууллаа.

3. Байгууллагын данс бүртгэл дэх 2,278.7 мянган төгрөгийн 5 нэр төрлийн эд хөрөнгийг бусдад эзэмшүүлсэн, дутагдуулсан байсан ба аудитын явцад шалгагдагч байгууллагаас тухайн иргэдэд мэдэгдэл хүргүүлснээр хөрөнгүүдийг буцаан хүлээн авч, зөрчлийг арилгасан байна.

**Шийдвэрлэсэн нь:** Аудитын явцад залруулсан алдаа, зөрчлийн талаар мэдээллийг шалгагдагч байгууллагын 2022.02.23-ны 76 тоот албан бичгээр хүлээн авсан.

#### 4.2 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор эрэмбэлэн харуулав. Үүнд:

##### 1. ***Төсвийн гүйцэтгэл, үр ашиг, арвилан хэмнэлттэй холбоотой асуудал***

**Илрүүлэлт:** Үйл ажиллагаа, хөтөлбөр арга хэмжээнд зарцуулсан хөрөнгийн үр дүнгийн тайлан, төсвийн дагуу гүйцэтгэлийн товч тайлан авч төсвийн хөрөнгийн үр өгөөжийг хянаж хэвшээгүй байна.

**Өгсөн зөвлөмж:** Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1-д “Төсвийн байгууллага нь түүний үйл ажиллагааг үр ашигтай удирдлагаар хангаж, ажлын үр дүнг хариуцах үүрэг бүхий төсвийн шууд захирагчтай байна”, 16.5.2. “Төсвийн шууд захирагч нь батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих”, 16.5.4. “Төсвийн шууд захирагч нь төсвийн байгууллагын үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэх” гэсэн заалттай нийцүүлж үйл ажиллагаа, хөтөлбөр арга хэмжээнд зарцуулсан хөрөнгийн үр дүнгийн тайлан, төсвийн дагуу гүйцэтгэлийн товч тайлан авч төсвийн хөрөнгийн үр өгөөжийг хянаж байх.

##### 2. ***Засгийн газрын 43 дугаар тогтоолын хэрэгжилттэй холбоотой асуудал***

**Илрүүлэлт:** Засгийн газрын 43 дугаар тогтоолыг үл хэрэгсэн үндсэн үйл ажиллагаанд зайлшгүй шаардлагатайгаас бусад хэмнэх боломжтой зардлыг хэмнэж ажиллаагүй. Тухайлбал: сургалт семинар зохион байгуулах үйл ажиллагаанд 14517.4 мянга, бичиг хэрэг, аж ахуй, бусад материалын үнэд 71656.0 мянган төгрөгийн зардал гаргасан байна.

**Өгсөн зөвлөмж:** Харьяалах дээд шатны байгууллага, Засгийн газрын тогтоол шийдвэрийн хэрэгжилтийг хангаж ажиллах.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Ховд аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 5 дугаар сарын 25-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

### 5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Д/Д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	ГБХЗХГ	5	190,575.3	3	183,409.7					2	7,165.6

#### АУДИТЫН ТАЙЛАНГ ХЯНАСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР:

Х.БОЛДБААТАР

АУДИТЫН МЕНЕЖЕР:

А.ЦЭЦЭГСҮРЭН

#### ТАЙЛАНГ БИЧСЭН:

АУДИТОР:

Б.ДОЛЖИНЖАВ

Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

**5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл**

Д/Д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс /мянган төгрөгөөр/							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	ГБХЗХГ	5	190,575.3	3	183,409.7					2	7,165.6

**АУДИТЫН ТАЙЛАНГ ХЯНАСАН:**

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР:  **Х.БОЛДБААТАР**

АУДИТЫН МЕНЕЖЕР:  **А.ЦЭЦЭГСҮРЭН**

**ТАЙЛАНГ БИЧСЭН:**

АУДИТОР:  **Б.ДОЛЖИНЖАВ**